

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

## АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1. Аудитын нэр

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

### 2. Аудитын код

/УАГ-НАГ /2014/01-НА/

### 3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны даргын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн "Аудитын сэдэв батлах" тухай З дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудитораас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

### 4. Аудитын зорилт

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн хуулийн дагуу үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж байгаа эсэхэд дараах зорилтын хүрээнд авч үзнэ. Үүнд:

1. Нэр бүхий сангудын мөнгөн хөрөнгийн бүрдүүлэлтийг хууль тогтоомжтой уялдуулан бодитой төлөвлөсөн байдал
2. Сангуудын хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж байгаа эсэх
3. Сангуудын хөрөнгийг зарцуулах бодлого, үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй байгаа эсэх,

### 5. Аудитын хамрах хүрээ

Аудитаар ЭМЯ, СЯ, ХАХНХЯ, ХЯ, МХТГазар, ХЗДХЯ, ГХЯ болон холбогдох бусад байгууллагуудын эрхлэн хариуцаж буй Монгол Улсын Засгийн газрын дараах тусгай сангудын 2013 оны үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- Эрүүл мэндийг дэмжих сан
- Хүний хөгжлийн сан
- Нийгмийн даатгалын сан
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан
- Архидан согтуурахтай тэмцэх сан
- Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан

### 6. Үндсэн мэдээлэл

Нийцлийн Аудитад хамрагдаж байгаа Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн орлогын эх үүсвэрт 2013 онд 1108,3 тэрбум төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1089,9 тэрбум төгрөг зарцуулж, төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 18,4 тэрбум төгрөг буюу 1,7 хувиар тасалсан байна. Үүнээс:

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 тоот тушаалаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн 2013 оны үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн хуваарилалт, зардлын жишгийг батлан хэрэгжүүлж байна.

Хүний хөгжлийн санд 173.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 31.4 хувиар буюу 79.3 тэрбум төгрөгөөр бага байна. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 58.6 тэрбум төгрөг, есөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн орлого 20.9 тэрбум төгрөгөөр дутуу биелүүлсэнтэй холбоотой байна. Хүний хөгжлийн сангийн зарлага 185.1 тэрбум төгрөгт хүрч, төсөвлөгдсөн нийт зардал 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант жилд тус сангаас хүүхдэд олгож байгаа бэлэн мөнгөний санхүүжилтээр 149.5 тэрбум төгрөг, иргэн бүрт олгох 21.0 мянян төгрөгийн санхүүжилтээр 27.4 тэрбум төгрөгийг олгоод байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого 834.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөг 9.1 хувь буюу 69.5 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлжээ. Тайлангийн хугацаанд тус санд улсын төсвөөс 215.7 тэрбум төгрөгийн татаасыг олгожээ. Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 97.8 хувь буюу 694.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Тус сангаас төрийн өмчит улсын эмнэлгүүдэд 58.1 тэрбум төгрөгийн татаасыг олгожээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 87.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 79,7 тэрбум төгрөг төвлөрүүлж, орлогыг 7.7 тэрбум төгрөг буюу 8.8 хувиар тасалсан нь авлагыг бүрэн хурааж төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд 3.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 2.7 тэрбум төгрөг төвлөрүүлж 0.9 тэрбум төгрөг буюу 25.8 хувиар тасалсан нь авлагыг бүрэн хурааж төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Архидан согтуурахтай тэмцэх сангийн үндсэн зорилго нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, согтуурсны улмаас хүн амын эрүүл мэнд, нийгэмд учирч байгаа хор уршигийг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд чиглэгджээ. Сангийн үйл ажиллагааг Сангийн зөвлөл удирдаж, Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлж ажилладаг. Сангийн зөвлөлийн ажлын алба нь Гэмт хөргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицулах зөвлөлийн ажлын алба байна.

Сангийн хөрөнгийг “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 132.2-т заасан эх үүсвэрээс бүрдүүлж санхүүжүүлдэг байна.

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.16, 26.3-т заасныг үндэслэн ЗГ-ын 2008 оны 3 дугаар сарын 19-ний 110 дугаар тогтооолоор Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дурмийг баталж, тус сан нь 2009 оны 4 дүгээр улирлаас үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгийг гадаадад урт, богино хугацаанд зорчиж буй иргэдийн тоотой харьцуулахад бага бөгөөд өнөөгийн байдлаар ихэвчлэн шарил, чандар авчурулах, амь насанд нь аюул учирсан, эмчлэгдэх аргагүй өвчин туссан иргэн болон гадаадад ял эдэлж дуусаад эх орондоо ирж буй иргэдэд туслахад зарцуулагдаж байна.

2013 онд Иргэдэд туслах сангийн зориулалтаар 280.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөгджэх эхний 9 дүгээр сарын 15-ны байдлаар 57 өргөдөл хүсэлтийн хүрээнд Сангийн дүрэмд заасны дагуу 4 чиглэлийн 39 тохиолдлын үндэслүүдэд 140.0 сая төгрөг зарцуулаад байна. Сангийн орлого 2013 онд 7.0 тэрбум төгрөг батлагдаж, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 8.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсөн байна.

## **7. Эрсдэлийн үнэлгээ**

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

## **8. Аудитын арга зүй**

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан зарим тусгай сангийн ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дун шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дун, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

## **9. Шалгуур үзүүлэлтүүд**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- Нэгдсэн төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт
- ЗГ-ын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журам
- 2006 оны 288 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн үүргийн үйлчилгээний санг бүрдүүлэх, зарцуулах журам”
- 2007 оны 92 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам”

## **10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б.Алтанзул, аудитын менежер З. Ариунзаяа нар удирдаж, ахлах шинжээч Я. Наранцэцэг, аудитор Ц.Эрдэнэчuluун, шинжээч Л.Нямтөмөр, Ш.Наанбаатар, Б.Билэгт нар гүйцэтгэнэ. Санхүүгийн аудитын газар, Аймаг, нийслэлийн аудитын газар хамтран оролцно.

## **11. Аудит хийх хугацаа**

Аудитыг 2014 оны 2 дугаар сарын 15-нд эхэлж, 5 дугаар сарын 15-нд дуусгаж, тайлагналын үе шатны ажлыг 5 дугаар сарын 16-аас эхэлж, 6 дугаар сарын 16-нд УИХ-д дүгнэлтийг танилцуулна.

## **12. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам**

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дун, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж болон хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг Монгол Улсын Ерөнхий аудитор болон УИХ-д танилцуулж, баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

### 13. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

- а. Боловсон хүчин: ҮАГ- 63 өдөр \*8хүн- 504 хүн/өдөр
- б. Орон нутгаас: 63 өдөр\*44 хүн- 2772 хүн/өдөр
- в. Санхүүгийн нөөц: Цалингийн зардал: 119.070,0 мянган төгрөг
- г. Үйл ажиллагааны зардал: 285.768,0 мянга төгрөг
- д. Мэргэжлийн шинжээчийн зардал: 2.160,0 мянган төгрөг
- е. Аудитын нийт зардал: 406.998,0 мянган төгрөг
- ё. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, сканиер, дектафон, болон бусад техник хэрэгсэл

### Аудитын төлөвлөгөөгөөр

Хянаж зөвшөөрсөн:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
ДЭД ДАРГА



Б.БАТТУЯА

Боловсруулсан:

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА




Б.АЛТАНЗУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР



З. АРИУНЗАЯА

АХЛАХ ШИНЖЭЭЧ



Я.НАРАНЦЭЦЭГ

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭЧУЛУУН

ШИНЖЭЭЧ



Л.НЯМТӨМӨР



Ш.НАРАНБААТАР



Б.БИЛЭГТ